

ХАСБАНК ХК

ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт орсон талаарх мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
Тайлагнах хугацаа	2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: ХасБанк ХК УБГД: 000239852 РД: 2578697 Үнэт цаасны код: MN00XAC05687 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72 Утас: 75771888 И-мэйл: info@xacbank.mn Вэбсайт: www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Н.Цэлмэгхишиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
1. ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт орсон талаарх мэдээлэл	
ХасБанк ХК (“Банк”)-ийн Дүрэм (“Дүрэм”)-д хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-нийн өдрийн SR-2025-04 болон SR-2025-05 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн ба Улсын бүртгэлийн ерөнхий газар өөрчлөлт орсон Дүрмийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр бүртгэсэн болно.	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр: Н.Цэлмэгхишиг

Албан тушаал: ТУЗ-ийн ажлын албаны хуульч

Гарын үсэг:



Хянасан:

Н.Мөнхцэлмэг

Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Огноо: 2025 он 06 сар 13 өдөр

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-04

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ") нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн тайланг хянан баталгаажуулахдаа Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5 болон 81.6 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн нэр дэвшүүлэх чиг үүргийг цалин урамшууллын чиг үүргээс тусгаарлах зөвлөмжийг ирүүлсэн болохыг;
- Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороог: (а) ТУЗ-ийн гишүүнийг нэр дэвшүүлэх, залгамж халааг төлөвлөн зохион байгуулах чиг үүрэг бүхий Нэр дэвшүүлэх хороо болон (б) компанийн засаглалын бодлого журам, ТУЗ-ийн бүтэц, цалин хөлсний бодлого, урамшууллын бүтцийг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий Засаглал, цалин урамшууллын хороо болгон бие даасан хоёр хороонд хувааж өөрчлөн байгуулах асуудлыг тусгаж Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг R-2025-08 тоот тогтоолоороо зөвлөмж болгосныг; мөн
- ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу, Хувьцаа эзэмшигчид Банкны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Дээр дурдсаныг үндэслэн, Банкны Дүрмийн дараах хэсгүүдэд доорх нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад	8.14. ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос <u>Нэр дэвшүүлэх хорооноос</u> тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад

дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.	дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.
8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь "Хороо", хамтад нь "Хороод" гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.	8.29. ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь "Хороо", хамтад нь "Хороод" гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.
8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.	8.30. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны <u>Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны</u> гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.
8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.	8.40. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, Нэр дэвшүүлэх болон <u>Засаглал</u> , цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

2. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 04 сарын 29 өдөр

№ SR-2025-05

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт оруулах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банк нь Ахмад настны тухай хууль (2017)-ийн дагуу Банкнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд дэмжлэг, тусламж үзүүлэх зорилгоор байгуулсан Ахмадын сантай болохыг;
- Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр компаниудад өөрийн дүрэмдээ Ахмадын сан байгуулах болон түүнд компанийн цалингийн нийт сангийн гурав хүртэлх хувь (3%)-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх асуудлыг тус тус тусгайлан тусгахыг үүрэг болгосныг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн R-2025-11 тоот тогтоолоор зөвлөмж болгосны дагуу, Банкны Дүрэмд Ахмадын сангийн зохицуулалтыг тусгах, хууль тогтоомжийн өөрчлөлтөд нийцүүлэх зорилгоор нэмэлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Дээрхийг үндэслэн, Банкны Дүрэмд дараах агуулга бүхий 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг нэмсүгэй:

Нэмэх заалт

5.5. Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.

- Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт дээр дурдсан Дүрмийн нэмэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж, бүртгүүлэхийг даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГУПТА



ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn



ХАСБАНК
НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ДҮРЭМ

Огноо: 2023.09.15

Нэмэлт өөрчлөлт оруулсан огноо: 2025.04.29

ДҮРЭМ

ГАРЧИГ

1. Нийтлэг үндэслэл
2. Банкны оноосон нэр болон хэлбэр
3. Эрхэм зорилго
4. Банкны тэмдэг
5. Банкны эрхлэх үйл ажиллагаа
6. Банкны хувьцаа эзэмшигчид
7. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө болон Хувьцаа
8. Банкны удирдлага болон зохион байгуулалт
9. Дотоод аудит болон хяналт
10. Банкийг татан буулгах
11. Банкны үйл ажиллагаанд хориглох зүйлс болон Банкны ажилтанд тавигдах шаардлага
12. Даатгал, Байгаль орчин болон нийгмийн бодлого
13. Бусад

ХАСБАНК ХК-ИЙН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн
дугаар 9007 001017
2025 он 06 сарын 12 өдөр
Улсын (хууль) бүртгэлийн
гарын үсэг

- 1.1. Энэхүү дүрэм нь ХасБанк ХК (цаашид “Банк” гэх)-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагаа, эрх үүрэг, хариуцлагыг тогтоон, хяналтыг хэрэгжүүлэх, банкныг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр хувийн, үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хувьцаат компанийн хэлбэртэй, Банкны тухай хуульд заасны дагуу банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банк байна.
- 1.3. Банк нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон Монгол Улсын Төв Банк (“Монголбанк”), Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”) болон Монголын Хөрөнгийн Бирж (“МХБ”)-ээс баталсан дүрэм, журам зэрэг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү Дүрмийг тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан байдлаар удирдлага болгон, тэдгээрт нийцүүлж ажиллана.
- 1.4. Банкны төв байр нь Монгол Улс, Улаанбаатар хотод байрлана.
- 1.5. Энэхүү Дүрэмд хэрэглэсэн том үсгээр эхлэн бичигдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 1.5.1 “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” гэж 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол Улсын хуулийг;
 - 1.5.2 “Эрх бүхий байгууллага” гэж Монгол Улсын Засгийн газар, түүний төрийн, бүс нутгийн, болон орон нутгийн бүхий л салбар нэгж байгууллага, төр, түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэгч гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн болон татварын, зохицуулалтын болон захиргааны эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлэгч аливаа аливаа агентлаг, алба, нэгж, бие даасан зохицуулагч байгууллага, шүүх, төв банк, болон аливаа бусад этгээд, болон дээр дурдсан этгээд тус бүрийн хувьд тэдгээрийн албан тушаалтан, албан хаагч, болон төлөөлөгчийг;
 - 1.5.3 “Зөвшөөрөл” гэж аливаа Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, бүртгэлийн баримт бичиг, гэрчилгээ, аливаа бусад зөвшөөрөл эсхүл тэдгээрээс чөлөөлснийг гэрчлэх баримт, Банк, зээлдүүлэгч болон хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрсөн, эрх олгосон аливаа баримт бичгийг;
 - 1.5.4 “Холбогдох хууль тогтоомж” гэж Монгол Улсын соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээ, мөн Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, Эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, захиргааны хэм хэмжээний акт, Засаг даргын захирамж болон (улсын эсхүл орон нутгийн

хэмжээнд) хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх байгууллагын шийдвэр, хэм хэмжээний актуудыг;

- 1.5.5 “Банкны тухай хууль” гэж 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Банкны тухай хуулийг;
- 1.5.6 “Дөрвөн том аудитын компани” гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 4 (дөрөв) том аудитын компанийг;
- 1.5.7 “ТУЗ” эсхүл “Төлөөлөн удирдах зөвлөл” гэж Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийг;
- 1.5.8 “Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээ” гэж Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, түүний үүрэг хариуцлагын цар хүрээ, хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөл, цалин, урамшуулал болон бусад урамшууллын чанартай олговрын талаар харилцан тохиролцон Банкны Гүйцэтгэх захирал болон Банкны хооронд байгуулагдах гэрээг;
- 1.5.9 “Компанийн тухай хууль” гэж 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Компанийн тухай хуулийг;
- 1.5.10 “Татан буулгах комисс” гэж Холбогдох хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөн Банкныг татан буулгах ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ТУЗ-өөс эсхүл шүүхээс томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс томилсон багийг;
- 1.5.11 “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” гэж 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай Монгол Улсын хуулийг;
- 1.5.12 “Байгаль орчин, нийгмийн бодлого” гэж ТУЗ-ийн 2018 оны 3-р сарын 28-ны өдрийн R-2018-12 дугаартай тогтоолоор өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулан баталсан Банкны байгаль орчин, нийгмийн бодлого, түүнд Банкнаас тухай бүр өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан эрх зүйн актыг;
- 1.5.13 “Толгой компани” гэж энэхүү Дүрмийг баталсан өдрөөс эхлэн Толгой компанийг Банкинд нэгтгэх хүртэл хугацаанд ХасБанкны нийт зарласан болон гаргасан хувьцааны 94.99 (ерэн дөрөв зууны ерэн ес) хувьтай тэнцэх 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг хувьцааг эзэмшиж буй Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 2595788 тоот регистрийн дугаартай Тэнгэр санхүүгийн нэгдэл ХХК-ийг;
- 1.5.14 “СТОУС” гэж Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг;
- 1.5.15 “Дотоод аудитор” гэж Банкны үйл ажиллагаанд тогтмол аудит хийх зорилгоор ТУЗ-өөс банкны дотоод аудитораар томилогдсон аудиторыг;
- 1.5.16 “Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж Банкны тухай хуульд тодорхойлсон Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг;
- 1.5.17 “Нэгтгэх ажиллагаа” гэж Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлэх зорилгоор Толгой компанийг Банкинд нэгтгэх, үр дүнд нь нэгтгэж байгаа хуулийн этгээд болох Банк үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлэн үлдэх, улмаар Толгой компанийн хувьцаа эзэмшигчид Банкны шууд хувьцаа эзэмшигчид болох ажиллагааг;

- 1.5.18 “Бүртгэлийн өдөр” гэж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг гаргах зорилгоор ТУЗ-өөс тогтоосон огноог;
- 1.5.19 “Холбогдох этгээд” гэж Банкны тухай хуульд заасан дараах утгатай байна, үүнд:
- (i) банкны нэгдлийн оролцогч;
 - (ii) банк, банкны нэгдлийн оролцогчийн хувьцааны 5 (тав) ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд;
 - (iii) хувьцааных нь 5 (тав) болон түүнээс дээш хувийг банк эзэмшдэг хуулийн этгээд;
 - (iv) хувьцааных нь 5 (тав) болон түүнээс дээш хувийг банкны эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд эзэмшдэг хуулийн этгээд;
 - (v) банк, банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд;
 - (vi) банкны эрхлэх үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг банктai нэгдмэл сонирхолтой этгээд;
 - (vii) эрх бүхий албан тушаалтных нь чиг үүргийг банкны эрх бүхий албан тушаалтан давхар гүйцэтгэдэг хуулийн этгээд;
 - (viii) банкны саналын эрхтэй хувьцааны 10 (арав) болон түүнээс дээш хувийг эрх бүхий албан тушаалтан нь эзэмшдэг хуулийн этгээд;
 - (ix) энэ заалтад заасан этгээдтэй нэгдмэл сонирхолтой бусад хувь хүн, хуулийн этгээд;
 - (x) Монголбанкнаас холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.
- 1.5.20 “Хариуцлага тооцохуйц үйл ажиллагаа” гэж энэхүү Дүрэм батлагдах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Авлигын эсрэг гарын авлагад тус бүрт нь тодорхойлсон Авлига, хээл хахууль, Залилангийн, Албадлагын шинжтэй, Үгсэн тохиролцсон аливаа үйлдэл, үйл ажиллагааг;
- 1.5.21 “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” гэж 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хуулийг;
- 1.5.22 “Хувьцаа” гэж Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банкнаас гаргаж, СЗХ болон МХБ-аас зөвшөөрөл олгож, тэдгээрт бүртгүүлсэн, хувьцаа эзэмшигч нарын Банкинд оруулсан хөрөнгө оруулалт болон тэдгээрийн ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх, Банкийг татан буулгасны дараа Банкны хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хүлээн авах болон Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрхийг баталгаажуулсан энгийн хувьцааг;
- 1.5.23 “Хувь нийлүүлсэн хөрөнгө” гэж хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй эргэлтэд гаргасан нийт энгийн болон давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг ойлгох бөгөөд Банкны зарласан боловч гаргаагүй болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа уг хөрөнгөд орохгүй;
- 1.5.24 “Ердийн олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 50 (тавь) хувь дээр нэмэх нь 1 (нэг) тоон хэмжээг;

- 1.5.25 “Дийлэнх олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 66.67 (жаран зургаа зууны жаран долоо)-оос дээш хувийг;
- 1.5.26 “Үнэмлэхүй олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 75 (далан тав)-аас дээш хувийг;
- 1.5.27 “Эцсийн өмчлөгч” гэж 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хуульд заасан утгаар ойлгоно.
- 1.6. Банк нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу ТУЗ-ийн шийдвэрээр салбар, тооцооны төв, мөнгөн хадгаламжийн болон валют арилжааны нэгж, төлөөлөгчийн газар байгуулж болно.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ОНООСОН НЭР БОЛОН ХЭЛБЭР

- 2.1 Банкны оноосон нэр нь монгол хэлээр “ХасБанк” ХК, англи хэлээр “ХасBank” JSC байна.
- 2.2 Банк нь хэлбэрийн хувьд нээлттэй хувьцаат компанийн (“нээлттэй ХК”) хэлбэртэй байна.
- 2.3 Банк нь хуулийн этгээд болохын хувьд эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ, хэлцэл байгуулах зэрэг бүхий л тохиолдолд “нээлттэй ХК” гэсэн товчлолыг ашиглана.
- 2.4 Банкны албан ёсны бүртгэлтэй хаяг нь:
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд Амарын гудамж,
ХасБанкны төв байр.
- 2.5 Хувьцаа эзэмшигч өөрөөр зөвшөөрсөн эсхүл Холбогдох хууль тогтоомжоор шаардаагүй бол Банк нь (i) тухайн хувьцаа эзэмшигчийн нэрийг ашигласан эсхүл дурдсан сурталчилгааны материалыг олон нийтэд гаргахгүй, тараахгүй; эсхүл (ii) Хувьцааг олон нийтэд санал болгохтой холбоотойгоор тухайн хувьцаа эзэмшигч нь Банкны эсхүл түүнтэй холбоотой этгээдийн “томоохон хувьцаа эзэмшигч” буюу Банкны “үүсгэн байгуулагч” болохыг дурдсан Хувьцааны танилцуулга баримт бичиг гаргахгүй байх үүрэгтэй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ЭРХЭМ ЗОРИЛГО

- 3.1. Банкны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж мөн орлого багатай болон алслагдсан хөдөө орон нутагт амьдарч байгаа санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдмал иргэдэд санхүүгийн цогц үйлчилгээг хүргэж, Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ашгийн өндөр түвшинтэй, санхүүгийн тогтвортой байгууллага бий болгоход оршино.



ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БАНКНЫ ТЭМДЭГ

- 4.1 Банк нь өөрийн оноосон нэр, бэлгэдэл бүхий тэмдэгтэй байх бөгөөд албан хэрэгт оршин байгаа газрын хаяг бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 4.2 Тэмдгийг банкнаас гаргаж буй албан ёсны шийдвэр, гэрээ хэлцэл болон дотоодод явуулах албан бичиг, бусад шаардлагатай гэж үзсэн баримт бичгүүдийг баталгаажуулахад хэрэглэнэ.
- 4.3 Тэмдгийг итгэмжлэгдсэн ажилтан хариуцан, хамгаалагдсан найдвартай газарт хадгална.

ТАВДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 5.1 Банк нь Монголбанк болон СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр Банкны тухай хуулиар зөвшөөрсөн дараах банк, санхүүгийн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - 5.1.1 мөнгөн хадгаламж;
 - 5.1.2 зээл;
 - 5.1.3 төлбөр тооцоо;
 - 5.1.4 өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
 - 5.1.5 гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
 - 5.1.6 үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;
 - 5.1.7 үнэт зүйлс хадгалах;
 - 5.1.8 гадаад төлбөр тооцоо хийх;
 - 5.1.9 үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
 - 5.1.10 санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх;
 - 5.1.11 хөрөнгө оруулалт, санхүү, банк, зээл, экспорт-импортын санхүүжилтийн асуудлаар зөвлөмж, мэдээлэл өгөх;
 - 5.1.12 даатгалын зуучлагч; болон
 - 5.1.13 Монголбанкнаас зөвшөөрсөн, Холбогдох хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа.
- 5.2 Банк нь үүсгэн байгуулагдахад эхний зөвшөөрлөөр аваагүй зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэхдээ Монголбанк, СЗХ-нд хүсэлт гарган нэмэлт зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авна.
- 5.3 Банк нь Холбогдох хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 5.4 Банкинд дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:
 - 5.4.1 Тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулан засварласан <https://www.un.org/sc/suborg/en/sanctions/un-sc-consolidated-list> НҮБ-ын албан ёсны цахим хуудсанд болон бусад байдлаар НҮБ-ын дүрмийн VII бүлгийн 41 дүгээр зүйлийн дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан зэвсгийн хориг, эдийн засаг, санхүү, худалдааны хориг арга хэмжээнд орсон аливаа хувь хүн, хуулийн этгээдтэй, эсхүл тэдгээрийн тусын тулд, эсхүл тийнхүү хориг арга хэмжээнд хамаарах

аливаа бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой, аливаа гэрээ, хэлцэл, гүйлгээ хийх;

5.4.2 Хариуцлага тооцохуйц ажиллагаа явуулах;

5.4.3 Албадлагын шинжтэй үйлдэл хийх буюу гэрээний нэг тал, нөгөө талын үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор нөгөө тал, түүний эд хөрөнгөд шууд болон шууд бусаар хохирол учруулсан, гэмтээсэн, гэмтээхээр заналхийлсэн үйлдэл хийх;

5.4.4 Үгсэн тохиролцсон үйлдэл хийх буюу аливаа бусад этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг зүй бус зорилгод хүрэхээр хоёр буюу түүнээс талуудын хоорондын харилцан тохиролцоо хийх;

5.4.5 Авлигын үйл ажиллагаа, үйлдэл хийх явуулах буюу аливаа гуравдагч этгээдийн үйлдэлд зүй бусаар нөлөөлөхийн тулд үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бусаар санал болгох, өгөх, хүлээн авах үйлдэл хийх;

5.4.6 Залилангийн үйлдэл хийх буюу эд хөрөнгийн болон эдийн ашиг сонирхлоор, эсхүл хүлээсэн үүргээсээ зайлсхийх зорилгоор санаатай болон болгоомжгүй байдлаар төөрөгдүүлэх, төөрөгдүүлэхийг завдах, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх аливаа үйлдэл, эс үйлдэхүйг үйлдэх;

5.4.7 Банкны эд хөрөнгө болон нөөцийг шамшигдуулах зүй бусаар ашиглах буюу санаатай болон болгоомжгүйгээр Банкны эд хөрөнгө болон аливаа нөөцийг зүй бусаар ашигласан үйлдэл хийх;

5.4.8 Саад учруулсан үйлдэл хийх, үүнд:

5.4.8.1 Банкинд хийх хяналт шалгалтад хамаарах аливаа нотлох баримт бичгийг устгасан, хуурамчаар үйлдсэн, өөрчилсөн, нуун дарагдуулсан үйлдэл хийн Банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах;

5.4.8.2 Хориглосон үйл ажиллагааны хүрээнд Банкинд хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор хянан шалгагч нарт хуурамч мэдээлэл өгөх;

5.4.8.3 Банкинд хийх хяналт шалгалттай холбоотой аливаа мэдээлэл, баримт бичиг, бүртгэл гаргуулан авах хүсэлтийг биелүүлэхгүй байх;

5.4.8.4 Банкинд хийх хяналт шалгалт болон тийнхүү хяналт шалгалтыг явуулахтай холбоотой аливаа мэдээллийг задруулахгүй байх зорилгоор аливаа этгээдийг заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлэх; эсхүл

5.4.8.5 аудит, шалгалт хийх, мэдээлэл олж авах Гэрээгээр тогтоосон эрхээ хэрэгжүүлэхэд илтэд саад учруулах; болон

5.4.8.6 хулгай хийх буюу бусдын өмчлөлийн хөрөнгийг хууль бусаар олж авах зэрэг хамаарна.

5.5 Банк нь Компанийн тухай хууль болон Ахмад настны тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгуулсан Ахмадын сантай байх ба санг Банкны ахмадын тооноос хамааран Банкны цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ. */Энэ хэсгийг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн SR-2025-045 дугаар тогтоолоор нэмсэн/*

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

6.1 Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд Банкны хувьцааг худалдан авах буюу эзэмших замаар хөрөнгө оруулсан Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд,

харьяалалгүй хүн банкны хувьцаа эзэмшигч байна. Банкны аль ч хувьцаа эзэмшигч нь Нэгтгэх ажиллагаа дуусгавар болсноос хойш хэдийд ч шууд болон шууд бусаар, дангаар болон өөрийн холбогдох этгээдийн хамт Банкны нийт гаргасан хувьцааны 20 (хорь) хувиас дээш хэмжээний хувьцааг эзэмшихгүй.

- 6.2 Холбогдох хууль тогтоомж болон энэхүү Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалтаар саналын хуудсаар санал авах тухай ТУЗ-ийн шийдвэрт заасан Бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч нь саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхтэй бүхий л асуудлаар эзэмшиж буй хувьцаа бүртээ нэг саналын эрх эдэлнэ.
- 6.3 Банкны нийт гаргасан хувьцааны 10 (арав)-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ямар ч үед тодорхой үндэслэл бүхий хүсэлт гаргах замаар Банкны санхүүгийн үйл ажиллагаанд зөвхөн Дөрвөн том аудитын компанийн аль нэгээр ээлжит бус аудит хийлгүүлэхийг шаардах эрхтэй. Хүсэлт гаргасан тухайн хувьцаа эзэмшигч нь тийнхүү түүний хүсэлтийн дагуу шалгалтыг хийсэн аудиторын зардлыг бүрэн хариуцна.
- 6.4 Банкны гаргасан нийт хувьцааны 5 (тав) болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, түүний дотор Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь нэмэлтээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал болон ТУЗ болон тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 (жар) хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар Банкны ТУЗ эсхүл Гүйцэтгэх захиралд гаргах эрхтэй. Хувьцаа эзэмшигчийн гаргасан санал нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.
- 6.6 Хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Банкийг татан буугдсаны дараа өөрийн эзэмшиж буй Хувьцааны тоотой хувь тэнцүүлэн Банкны үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хүлээн авах эрхтэй.
- 6.7 Хувьцаа эзэмшигч нь Банкны зүгээс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөтлөхөд нь шаардлагатай гэж үзэж хүссэн аливаа мэдээлэл, баримт бичгийг Банкинд гаргаж өгнө.
- 6.8 Дүрмийн 6.7-д зааснаас гадна хувьцаа эзэмшигчид нь Банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх үүрэг бүхий этгээд болон холбогдох брокерууд, үнэт цаасны хадгаламжийн төвд өөрийн нэр болон оршин суугаа хаягийн мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

- 6.9 Хувьцаа эзэмшигчид нь Банкны аливаа үүрэг, хариуцлагыг хариуцан хүлээхгүй бөгөөд Банкинд Хувьцаа хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалтынхаа хэмжээгээр алдагдлын эрсдэлийг хүлээнэ.

Банкийг Нэгтгэх

- 6.10 Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд нь бүрэн хангаж биелүүлэх үүднээс Банк нь Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Хувьцаагаа олон нийтэд санал болгосны дараа (“Хувьцаагаа олон нийтэд санал болгох”) нэн даруй Толгой компанийг нэгтгэх ажиллагааг эхлүүлнэ. Нэгтгэх ажиллагаа дууссаны дараа Банк нь үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлэн явуулах бөгөөд Толгой компанийн хувьцаа эзэмшигчид нь Банкны шууд хувьцаа эзэмшигчид болно.
- 6.11 Хувьцааг олон нийтэд санал болгосны дараа Нэгтгэх ажиллагааг хамгийн боломжит богино хугацааны дотор буюу Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө хэрэгжүүлж дууссан байна. Төрийн аливаа эрх бүхий байгууллагаас эсхүл хуулийн дагуу дээрх эцсийн хугацааг сунгасан, түр зогсоосон, хойшлуулсан, эсхүл цуцалсан эсэхээс үл хамааран Банк нь Нэгтгэх үйл ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө эсхүл хамгийн ойр боломжит хугацаанд гүйцэтгэх зорилготой хэвээр байна.
- 6.12 Дүрмийн 6.10 – 6.12-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон Гүйцэтгэх захирал тус бүр нь Нэгтгэх ажиллагаатай холбогдуулан шаардагдах бүхий үйл ажиллагаа, баримт бичиг, болон бусад шаардлагатай зүйлсийг хийж гүйцэтгэх, үйлдэж, гарын үсэг зурж, хүргүүлэх, дээрх үйлдлүүдийг гүйцэтгэхийг Банкинд даалгах үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрх

- 6.13 Хувьцаа эзэмшигч бүр Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасны үндсэн дээр Банкны нэмж гаргасан хувьцаа эсхүл хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байна.
- 6.14 Хувьцааг шилжүүлэх тохиолдолд тийнхүү Хувьцааг шилжүүлэх санал гаргах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Банкны тухай хууль, болон Монголбанкнаас баталсан дүрэм, журмыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх бөгөөд Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу Банкны жижиг хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй хэвээр байна.
- 6.15 Банк нь хувьцаа эзэмшигч нарт нэмж хувьцаа, үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлд нэмж гаргах хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, нэмж гаргах хувьцааг худалдан авах нөхцөл, журам зэргийг заасан байна.

- 6.16 Аливаа холбогдох Зөвшөөрөл, үүний дотор Монголбанк, СЗХ болон МХБ-ийн бүртгэл хийх шийдвэр, зөвшөөрлийг авсны үндсэн дээр Банкны санал болгон шинээр гаргаж буй Хувьцаа, үнэт цаасыг худалдан авах хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хуульд заасан хувьцаа эзэмших дээд хязгаарт нийцүүлэн өөрийн эзэмшиж буй Хувьцаанд хувь тэнцүүлэн худалдан авах хүсэлтэй байгаа Хувьцаа болон бусад үнэт цаасны тоог тийнхүү шинээр нэмж Хувьцаа, үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 30 (гуч) өдрийн дотор Банкинд мэдэгдэнэ. Хэрэв 6.16-д заасны дагуу хувьцаа эзэмшигчид нь Банкнаас санал болгон шинээр гаргаж буй нийт Хувьцаа, үнэт цаасны тоо хэмжээнээс бага хэмжээний худалдан авах захиалга хийсэн тохиолдолд 6.16-д заасны дагуу Хувьцаа худалдан авахаар захиалсан хувьцаа эзэмшигчдэд тэдний захиалсан Хувьцаа, үнэт цаасны тоогоор худалдан авахыг зөвшөөрөх бөгөөд захиалагдаагүй үлдсэн Хувьцааг Банк нь нээлттэй хөрөнгийн зах зээл дээр шинэ хөрөнгө оруулагчид худалдах эрхтэй. Банкнаас санал болгон шинээр нэмж гаргаж буй Хувьцаа болон бусад үнэт цаасны тооноос давсан хэмжээгээр захиалга ирсэн тохиолдолд санал болгосон нэмэлт Хувьцаа, үнэт цаасыг захиалсан хувьцаа эзэмшигч нарын дунд хувь тэнцүүлэн хуваарилах бөгөөд энэ зүйлд заасан “хувь тэнцүүлэх” гэдгийг Банкны санал болгон шинээр нэмж гаргаж буй Хувьцаа, үнэт цаасыг авах хүсэлтэй тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй Хувьцааны тоог тийнхүү Хувьцааг шинээр нэмж гаргахаас өмнө эзэмшиж байсан тухайн санал болгосон Хувьцаа, үнэт цаасыг авах хүсэлтэй нийт хувьцаа эзэмшигчдийн Хувьцааны нийт тоонд хувааж тооцсоныг ойлгоно.

Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч

- 6.17 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох гэж буй аливаа хувьцаа эзэмшигч нь Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банкинд мэдэгдэж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд ингэснээр Банк Монголбанкнаас Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох урьдчилсан зөвшөөрлийг авах ажилд туслалцаа үзүүлэх боломжтой болно.
- 6.18 Хэрэв Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй Хувьцааны тоо, хэмжээнд аливаа өөрчлөлт орвол, тухайн хувьцаа эзэмшигч нь Холбогдох хууль тогтоомжоор шаардсан холбоотой бүхий л мэдээлэл, баримт бичгийг Банкны тухай хууль болон холбогдох журмын дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авах зорилгоор Банкинд гаргаж өгөх үүрэгтэй.
- 6.19 Энэхүү Дүрмийн 6.17 болон 6.18-д заасан Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй холбоотой аливаа шийдвэр, хэлцэл нь гагцхүү Монголбанкнаас зөвшөөрөл авснаар хүчин төгөлдөр болно. Банкны тухай хуулийн дагуу энэхүү Дүрмийн 6.17 болон 6.18-д заасныг зөрчин олж авсан Хувьцаа нь саналын эрх болон ногдол ашиг хүртэх аливаа эрхгүй байна.

ДОЛДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ХУВЬЦАА

- 7.1 Банкны нийт зарласан хувьцаа нь 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.



- 7.2 Дүрэм батлагдсан өдрийн байдлаар Банк нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг хувьцаа гаргасан бөгөөд улмаар Банк нь 105,270,000,000 (нэг зуун таван тэрбум хоёр зуун далан сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.
- 7.3 Хувьцаа бүр хувьцаа эзэмшигчдийн Банкинд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлэх бөгөөд Холбогдох хууль тогтоомжийн дагуу санал өгөх, ногдол ашиг авах, Банкныг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас орсон орлогоос хүртэх эрхийг гэрчилнэ.
- 7.4 Хувьцааны тоо нь Хувьцаа эзэмшигчийн санал өгөх, ногдол ашиг хүртэх, алдагдлын хариуцлагыг хүлээх хэмжээг тодорхойлно.

Банк хувьцаа, үнэт цаас нэмж гаргах, хувьцааг эргүүлэн худалдаж авах

- 7.5 Банк нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу авбал зохих зохих Зөвшөөрөл, журмын дагуу тухай бүр нээлттэй болон хаалттай захиалгын үндсэн дээр нэмэлт Хувьцаа болон Банкны хувьцаанд хөрвөх үнэт цаас, түүний дотор үндэслэн давуу эрхийн хувьцаа, опцион, вексель зэргийг гаргаж болно.
- 7.6 Банкнаас Хувьцаа нэмж гаргах, хувьцаа худалдан авах опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах тухай шийдвэр, түүний нөхцөлийг Банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.
- 7.7 Энэхүү Дүрмийн 7.6-д заасны дагуу нэмж гаргах Хувьцаа болон бусад үнэт цаас, хувьцаанд хөрвөх үнэт цаасны нийт тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх хугацаа, үнэ, эргүүлэн худалдаж авах үнийг ТУЗ тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
- 7.8 ТУЗ нь үнэт цаас болон Хувьцааны нэрлэсэн үнийг Компанийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтооно.
- 7.9 Банкны шинээр болон нэмж гаргасан үнэт цаас, болон Хувьцааны төлбөрийг зөвхөн бэлэн мөнгөөр хийнэ.
- 7.10 Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.10 дахь хэсэгт заасны дагуу Банк нь Монголбанк, МХБ, СЗХ-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр Банкны нийт гаргасан Хувьцааны 5 (тав)-аас дээш хувийн хувьцаа болон бусад үнэт цаасыг эзэмшигчээс нь эргүүлэн худалдаж авах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.

- 7.11 Банк хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь болон хэсэгчлэн эргүүлэн худалдан авч болно. Хувьцааг эргүүлэн худалдан авч буй тохиолдолд эргүүлэн худалдан авч буй хувьцааны тоо нь тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 (хорин тав) хувиас хэтэрч болохгүй.
- 7.12 Банкны эргүүлэн худалдан авсан Хувьцаа нь саналын эрхгүй, Банкны зарласан хувьцааны тоонд нөлөөлөхгүй бөгөөд энэ нь Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй халаасны хувьцаанд тооцогдоно. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банк нь халаасны хувьцааг дахин гаргаж болно.
- 7.13 Банк эргүүлэн худалдан авсан Хувьцааны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, худалдагчийн зөвшөөрсөн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээр хийж болно.
- 7.14 Банк нь Нэмж Хувьцаа болон үнэт цаас гаргах, Банкны Хувьцааг эргүүлэн худалдан авах зэрэг, зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд аливаа өөрчлөлт оруулах тохиолдолд Банкны тухай хуулийн дагуу Монголбанкнаас тухай бүр урьдчилан зөвшөөрөл авч, СЗХ, МХБ-д бүртгүүлнэ.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ УДИРДЛАГА БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

- 8.1 Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны Ердийн олонх буюу түүнээс дээш хэмжээний Хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Өмнөх өгүүлбэрт заасан ирц бүрдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахгүй бөгөөд дахин хуралдах өдрийг Компанийн тухай хуулийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулахтай холбоотой заалтын дагуу зарлан хуралдуулах ба тухайн хойшлуулсан хурал нь Бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны Ердийн олонх Хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 8.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 8.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрөв) сарын дотор буюу жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдөр (оролцуулан)-ийн дотор зарлан хуралдуулна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаас бусад бүх эрх, бүрэн эрх дуусгавар болно.
- 8.4 Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг болон Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан хувьцаа

эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал болон ТУЗ-ийн ирэх санхүүгийн жилийн төсвийг батлах асуудал нь гагцхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.

- 8.5 Холбогдох хууль болон Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тухайн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон хувьцаа эзэмшигчдийн Ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.
- 8.6 Дор дурдсан асуудлыг энэхүү Дүрэмд заасан “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ. Стратегийн ач холбогдол бүхий асуудлын талаар аливаа шийдвэрийг гагцхүү ТУЗ-өөр хэлэлцсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна:
- (i) Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх, бууруулах, Хувьцааг хуваах, эсхүл буцаан нэгтгэх, нийт гаргасан Хувьцааны 5 (тав) хувиас дээш хувийг эргүүлэн авах зэргээр Банкны өөрийн хөрөнгийн бүтцэд аливаа материаллаг өөрчлөлт оруулах;
 - (ii) ногдол ашиг тараах болон хуваарилах аливаа шийдвэр;
 - (iii) СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувиас дээш дүнгээр шинэ компани үүсгэн байгуулах, нэгтгэх, эзэмших, хөрөнгө оруулах аливаа шийдвэр гаргах;
 - (iv) Нэмж Хувьцаа, хувьцаанд хөрвөх аливаа төрлийн үнэт цаас гаргах (өмнө, эсхүл дараа нь зөвшөөрөл авснаар), аливаа төрлийн Хувьцаа болон үнэт цаас нэмж гаргах зөвшөөрөл олгох, эсхүл Банкны Хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдан авах зорилгоор опцион, баталгаа гаргах;
 - (v) ТУЗ-ийн төсөв, цалин урамшууллын хэмжээг тогтоох, ТУЗ-ийн гишүүдийн тоог ихэсгэх болон багасгах;
 - (vi) Банкны хувьцааг гадаадын хөрөнгийн биржид бүртгүүлэн худалдах;
 - (vii) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувиас дээш дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр компанид хөрөнгө оруулах;

- (viii) Өөрчлөн байгуулах, нийлэх, өөрчлөх, нэгтгэх буюу нийлүүлэх, Банкныг өөр компани, хуулийн этгээдтэй нэгтгэх, нийлүүлэх, эсхүл өөр компани, хуулийн этгээдийн хөрөнгийг бүхэлд нь эсхүл дийлэнх хэсгийг Банк худалдан авч эзэмших талаар төлөвлөгөө, шийдвэр гаргах;
- (ix) Банкны үйл ажиллагаанд аливаа өөрчлөлт оруулах;
- (x) Дөрвөн том аудитын компаниас бусад аудитын компаниуд дундаас Хөндлөнгийн аудиторыг сонгох тохиолдолд тийнхүү Банкны Хөндлөнгийн аудиторуудыг томилох, чөлөөлөх;
- (xi) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр Банкны нийт хөрөнгийн 25 (хорин тав) хувиас илүү үнэлгээ бүхий аливаа хөрөнгийг худалдах, тээвэрлэх, шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах.

8.7 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаар товлосон өдрөөс 40 (дөч)-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн аливаа хурлын талаарх мэдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаар товлосон өдрөөс 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулахтай холбоотой бүхий л асуудлууд, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хуралдуулах, бэлтгэх шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл хүргүүлэх, хурлыг зохион байгуулах, хуралдуулах, санал хураалт, санал тооллогын журам болон тооллогын комиссын чиг үүрэг, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл хөтлөх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, хурдын тэмдэглэлийг хянан баталгаажуулах, хүргүүлэх зэрэг асуудлыг СЗХ-ноос баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргүүлэх тухай журам болон ТУЗ-ийн баталсан холбогдох дотоод журмаар зохицуулна.

8.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг биечлэн оролцох хуралдааны эсхүл теле-конференцийн болон бусад ижил төстэй харилцаа холбооны хэрэгслийг ашиглан цахим аль ч хэлбэрээр хуралдуулж болох бөгөөд хурлын дэгийг ТУЗ тогтооно. Хувьцаа эзэмшигчдийн хурал болон харилцаа холбоог англи хэлээр явуулах бөгөөд энэ тохиолдолд Банк нь орчуулагч, орчуулах төхөөрөмжөөр хангах замаар тухайн хуралд оролцож буй бүх хувьцаа эзэмшигчид нь хурлаар хэлэлцэж буй асуудлыг бүрэн ойлгох, мэдээлэлтэй байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

8.9 Холбогдох хууль тогтоомж эсхүл энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргална. ТУЗ-ийн дарга нь өөрийн эзгүй үед хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлнэ. ТУЗ-ийн дарга тийнхүү нэр дэвшүүлээгүй бол ТУЗ-өөс томилсон этгээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргална.

- 8.10 Компанийн тухай хуулиар зөвшөөрсөн хэмжээнд ТУЗ зохимжтой гэж үзсэн бол хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт (цаашид “Эчнээ санал хураалт” гэх) явуулах замаар шийдвэрлэж болно. Энэхүү Дүрмийн 8.1-д заасан хурлын хүчинтэй ирцэд тавигдах шаардлага Эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэр гаргах болон хойшлуулсан Эчнээ санал хураалтад мөн адил хамаарна.
- 8.11 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.
- 8.12 Энэхүү Дүрмээр зохицуулагдаагүй бусад асуудлууд, тодруулбал хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар болон хэлэлцэх асуудлын жагсаалт хүргүүлэх, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргах, хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох, хуралд оролцох эрх, хурлыг хуралдуулах буюу зохион байгуулах, хурлын ирц хүчин төгөлдөр болох, санал хураах, саналын тооллого болон хувьцаа эзэмшигчид эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах зэрэг асуудлыг Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасны дагуу тодорхойлж шийдвэрлэнэ.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

- 8.13 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан 12 (арван хоёр) гишүүнтэй байна (ТУЗ-ийн гишүүн чөлөөлөгдсөн эсхүл нас барсан гэх зэрэг онцгой тохиолдлуудад ТУЗ-ийн гишүүдийн тоо түр хугацаанд 12-оос бага болсноос бусад үед).
- 8.14 ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ. */Энэ хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн SR-2025-04 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 8.15 Холбогдох аргачлал болон Монголбанкны Ерөнхийлөгчийн олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хурал нь СЗХ-оос баталсан журмын дагуу санал хураах кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүдийг томилно.
- 8.16 Энэхүү Дүрэмд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үүргээ зохих ёсоор биелүүлж байх тохиолдолд ТУЗ-ийн бүрэн эрх 2 (хоёр) жилийн хугацаатай байна. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний орон тоо гарсан тохиолдолд Монголбанкны зөвшөөрлийг авч ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд ТУЗ түр томилж, энэ талаар хувьцаа

эзэмшигчдэд 14 (арван дөрөв) хоногийн дотор мэдэгдэнэ. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн гишүүний бүхий л эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

- 8.17 ТУЗ-ийн хурлыг биечлэн оролцох хуралдааны эсхүл теле-конференцийн болон бусад ижил төстэй харилцаа холбооны хэрэгслийг ашиглан цахим аль ч хэлбэрээр хуралдуулж болох бөгөөд хурлын дэгийг ТУЗ тогтооно. ТУЗ-ийн гишүүдийн Дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурлын хүчинтэйд тооцогдоно. ТУЗ-ийн хурал болон хурлын харилцаа холбоог англи хэлээр явуулж, тухайн хуралд оролцож буй бүх гишүүд харилцан нэг нэгнээ сонсох нөхцөлийг бүрдүүлж, тийнхүү оролцсоныг хуралд биечлэн оролцсонд тооцно.
- 8.18 Энэхүү Дүрэм болон Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн Дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болох бөгөөд ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.
- 8.19 Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж Банкны тэмдгийг дарж баталгаажуулна. ТУЗ-өөс зохимжтой гэж үзсэн бол ТУЗ нь ТУЗ-ийн хурал хуралдуулахгүйгээр ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт (эчнээ санал хураалт) явуулах замаар шийдвэр гаргаж болно.
- 8.20 ТУЗ-ийн даргыг нийт гишүүдийн дотроос нийт гишүүний Дийлэнх олонхийн саналаар томилох бөгөөд нэр дэвшигч гишүүний саналыг тооцохгүй. ТУЗ-ийн дарга нь өөрийн эзгүй үед ТУЗ-ийн хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлнэ. ТУЗ-ийн дарга тийнхүү нэр дэвшүүлээгүй бол ТУЗ-өөс томилсон этгээд ТУЗ-ийн хурлыг даргална.
- 8.21 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж гаргасан хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга эсхүл аль нэг гишүүн нь дангаараа болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар аливаа шийдвэр гаргах буюу ТУЗ-ийг төлөөлөх эрхгүй. ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-өөс тусгайлсан өгсөн зөвшөөрөлгүйгээр ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.
- 8.22 ТУЗ нь хуанлийн жилийн улирал тутамд хамгийн багадаа 1 (нэг) удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд үзвэл нэмэлт хурал хийж болно.
- 8.23 Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаатай холбоотой журмыг ТУЗ батална.
- 8.24 ТУЗ-ийн гишүүд нь хуралд оролцож байгаа бүх гишүүд бие биенээ харилцан сонсох боломжтой теле-конференцийн эсхүл түүнтэй адил харилцаа холбооны бусад хэрэгслээр дамжуулан ТУЗ-ийн хуралд оролцож болох бөгөөд тухайн хуралд оролцож буй бүх гишүүд харилцан нэг нэгнээ сонсох нөхцөлийг бүрдүүлж, тийнхүү оролцсоныг хуралд биечлэн оролцсонд тооцно.
- 8.25 Энэхүү Дүрэм болон ТУЗ-ийн баталсан аливаа дүрэм, журмаар зохицуулагдаагүй ТУЗ, түүний бүрэн эрх, үйл ажиллагаа, хурал, шийдвэртэй холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлэг,

холбогдох бусад хууль тогтоомжид мөн ТУЗ-өөс Компанийн Засаглалын Кодекст нийцүүлэн ТУЗ-өөс баталсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу тодорхойлж зохицуулна.

8.26 ТУЗ нь Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна энэхүү Дүрэм болон Компанийн тухай хуульд тухайлан хувьцаа эзэмшигчдийн хуралд харьяалуулснаас бусад дор дурдсан асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

8.26.1 СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувь хүртэлх дүнгээр шинэ компани үүсгэн байгуулах, нэгтгэх, эзэмших, хөрөнгө оруулах аливаа шийдвэр гаргах;

8.26.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувь хүртэлх дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр аливаа компанид хөрөнгө оруулах;

8.26.3 Дөрвөн том аудитын компаниас аудиторыг сонгох тохиолдолд тийнхүү Банкны хөндлөнгийн аудиторуудыг томилох, чөлөөлөх.

8.27 ТУЗ-ийн Дарга болон гишүүд нь Холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүрэг, хариуцлагаас гадна дараах үүрэгтэй:

8.27.1 хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх;

8.27.2 Банк, Банкны харилцагчийн эрх ашгийг хувийн болон түүнийг томилсон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих;

8.27.3 нууцаар ашиг хүртэхгүй байх;

8.27.4 сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;

8.27.5 банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх.

8.28 ТУЗ нь ТУЗ-ийн гишүүнийг сонгох, сонгууль явуулах журам, ТУЗ-ийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хурал хуралдуулах буюу зохион байгуулах журам, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэл, гишүүнийг түр томилох, нөхөн сонгууль явуулах, гишүүдэд тавих шалгуур зэрэг харилцааг зохицуулсан дотоод журмыг Монголбанкинд урьдчилан танилцуулан батлуулж мөрдүүлнэ.

ТУЗ-ийн хороод

8.29 ТУЗ нь ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “Хороо”, хамтад нь “Хороод” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах

зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна. /Энэ хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн SR-2025-04 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/

- 8.30 Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын, Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3 (гуравны хоёр)-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бүс гишүүн байна. /Энэ хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн SR-2025-04 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/
- 8.31 Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, болон Монголбанк, СЗХ-ноос баталсан холбогдох бусад дүрэм, журмын дагуу Хороодын гишүүдийг томилох, чөлөөлөх, Хороодын эрх, үүрэг, хариуцлагыг ТУЗ-өөс баталсан холбогдох журмаар зохицуулна.
- 8.32 Хороо тус бүрийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь тухайн ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа буюу 2 (хоёр) жилийн хугацаанд эсхүл энэхүү хоёр хугацааны аль богино хугацаагаар үргэлжилнэ.
- 8.33 Хороод нь тухайн Хорооны бүхий л хурлын даргалах даргалагчийг тухайн Хорооны гишүүд дотроосоо сонгоно.
- 8.34 Хорооноос үүргээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан зохих баримт бичгийг Банк нь гаргаж өгөх үүрэгтэй.
- 8.35 Хорооны хурлыг хуанлийн жилийн улиралд 1 (нэг)-ээс доошгүй удаа эсхүл тухайн нөхцөл байдлаас шалтгаалан үүнээс олон удаа хуралдуулна. Хорооны хуралд тус Хорооны гишүүдийн Ердийн олонх нь биечлэн оролцсоноор хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцно.
- 8.36 Хороо тус бүрийн үйл ажиллагааны журам, хурлын хүчин төгөлдөр ирц, болон Компанийн тухай хуулиар тухайн Хороонд тусгайлан олгосон эрх, үүргээс бусад бүрэн эрхийг ТУЗ батална.

Гүйцэтгэх удирдлага

- 8.37 Холбогдох аргачлал зааварчилгааны дагуу мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хууль тогтоомжийн шаардлага болон энэхүү Дүрэмд нийцүүлэн ТУЗ-тэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулж ажиллана.
- 8.38 Компанийг төлөөлөн ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захиралтай Хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд тус гэрээгээр Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг тодорхойлон зохицуулна.
- 8.39 Гүйцэтгэх Захирал нь хэлэлцэж буй асуудлаар саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүн байж болох боловч ТУЗ-ийн дарга байж болохгүй.



- 8.40 Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Засаглал, цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна. */Энэ хэсэгт 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн SR-2025-04 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан/*
- 8.41 Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд ТУЗ хяналт тавина. ТУЗ-ийн шийдвэргүйгээр ТУЗ-ийн аль нэг гишүүн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хянан шалгах, эсхүл Гүйцэтгэх Захиралд үүрэг, даалгавар өгөхийг хориглоно.
- 8.42 Гүйцэтгэх Захирал нь банкны эрхлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд, Банкны эрхэм зорилгод нийцсэн зах зээлд өрсөлдөх чадвартай, харилцагчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц үйлчилгээг үр ашигтайгаар түргэн шуурхай үзүүлэх ажлыг бүхий л боломжит нөөц, эх үүсвэрийг ашиглан зөв оновчтой зохион байгуулж ажиллах замаар банкны эдийн засаг, санхүүгийн чадавхыг дээшлүүлэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нэмэгдүүлэх үндсэн үүрэгтэй байна.
- 8.43 Гүйцэтгэх захирал нь ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлаар уг албан тушаалд олгогдсон эрх хэмжээ буюу үүрэг, хариуцлагаа бие даан хэрэгжүүлнэ. Хөдөлмөрийн гэрээ, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Холбогдох хууль тогтоомжид заасан болон дараах албан үүрэг, хариуцлагыг хүлээнэ:
- 8.43.1 Банкны үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлийн ирээдүйн чиг хандлага, бодлого чиглэлийг тодорхойлох, тогтоох, хэрэгжүүлэх;
- 8.43.2 Банкны салбар, тооцооны төв, хадгаламжийн касс, валютын арилжааны нэгж, төлөөлөгчийн газар, газар, алба, хэлтсийг удирдан зохион байгуулах;
- 8.43.3 Банкийг олон нийт, засгийн газар, бусад эрх бүхий байгууллагуудын өмнө төлөөлөх;
- 8.43.4 Банкны зээл болон хадгаламжийн хүү, үйлчилгээний хураамж, бусад шимтгэлийн хэмжээг тогтоох;
- 8.43.5 Дүрэм, гэрээ контрактад заасан эрхээ хэрэгжүүлэхдээ, Банкийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
- 8.43.6 шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах;
- 8.43.7 Гүйцэтгэх захирал нь өөрийн үйл ажиллагааг ТУЗ-ийн хуралд тогтмол тайлагнана;
- 8.43.8 Гүйцэтгэх захирал нь Монголбанкнаас тогтоосон болон Банкны тухай хуульд заасан банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангах үүргээ санаатайгаар зөрчсөн, Холбогдох хууль тогтоомжид

нийцээгүй, энэ Дүрэм болон Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсхүл дээрх үүргүүдээ ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ нь Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлж болно.

Эрх бүхий албан тушаалтан

8.44 Банк нь дараах эрх бүхий албан тушаалтантай байна:

8.44.1 ТУЗ-ийн дарга;

8.44.2 ТУЗ-ийн гишүүн;

8.44.3 Гүйцэтгэх захирал;

8.44.4 Санхүү хариуцсан захирал/Ерөнхий нягтлан бодогч;

8.44.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

8.44.6 Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний дагуу удирдлагын түвшинд үүрэг гүйцэтгэж байгаа бусад албан тушаалтан.

8.45 Гүйцэтгэх захирлаас итгэмжлэн олгосон эрх, үүргийн хүрээнд гэрээ байгуулах, тодорхой үйлдэл хийх, эсхүл Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд Банкийг гуравдагч этгээдийн өмнө төлөөлсөн нь тухайн ажилтныг эрх бүхий албан тушаалтан гэж үзэх үндэслэл болохгүй.

8.46 Холбогдох хууль тогтоомжид заасан доорх нөхцөлөөс бусад тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь өөрийн хүлээсэн үүргээ зөрчсөнөөс учирсан аливаа хохирлыг Банк, Банкны хувьцаа эзэмшигчдийн өмнө биечлэн хариуцахгүй. Үүнд:

8.46.1 Эрх бүхий албан тушаалтан нь Банк, болон түүний хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үнэнч байх үүргээ зөрчсөн;

8.46.2 шударга бус үйлдэл, эсхүл санаатай үйлдэл, эсхүл хууль тогтоомжийг санаатайгаар зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй; эсхүл

8.46.3 Хувийн ашиг сонирхлын төлөө болон хувьдаа ашиг олох зорилгоор аливаа хэлцэл хийсэн.

8.47 Эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг багасгах, эсхүл хязгаарлах замаар Холбогдох хууль тогтоомжид аливаа нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд тухайн эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлага нь тийнхүү нэмэлт өөрчлөлт орсон хуулиар тодорхойлсон хэмжээгээр мөн багасгах буюу хязгаарлагдана.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. ДОТООД АУДИТ БОЛОН ХЯНАЛТ

9.1 Аудитын хороо нь Банкны ТУЗ-ийн баталсан санхүүгийн бодлого болон үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хяналт тавьж ажиллана. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.

9.2 ТУЗ нь өөрийн Аудитын хороогоор дамжуулан Банкны санхүүгийн тайланг баталгаажуулах, Банкны санхүүгийн үйл ажиллагаанд ээлжит иж бүрэн аудитын шалгалт хийх хөндлөнгийн аудиторыг шалгаруулан авч ажиллуулна.

АРАВДУГААР ЗҮЙЛ. БАНКИЙГ ТАТАН БУУЛГАХ

- 10.1 Банкнийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн оролцсон, уг асуудлаар санал өгөх эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн Үнэмлэхүй олонхийн саналаар буюу Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Холбогдох бусад хууль тогтоомжид заасан бусад үндэслэл, журмын дагуу татан буулгаж болно.
- 10.2 Татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах тохиолдолд шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгчээс томилогдсон Татан буулгах комисс хэрэгжүүлнэ.
- 10.3 Банкнийг татан буулгах үед Банкны мөнгөн төлбөрийн үүрэг болон бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа хөрөнгө (үүнд эд хөрөнгө худалдсанаас олсон аливаа орлого багтана) үлдсэн бол аливаа хөрөнгийг Компанийн тухай хуульд заасан журмаар хуваарилна.
- 10.4 Татан буулгах ажиллагааг Иргэний хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ, БАНКНЫ АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 11.1 Банкны үйл ажиллагаанд дор дурдсан хязгаарлалт тавина. Үүнд:
 - 11.1.1 ТУЗ-өөс баталсан төсөвт тусгасан эсхүл ТУЗ-ийн тусгайлан шийдвэр гаргаж зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банк нь шинэ бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, шинээр салбар, хуулийн этгээд байгуулахыг хориглоно;
 - 11.1.2 Банкны ТУЗ зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны төсөвт тусгагдаагүй нэг төсөл буюу тодорхой нэг зорилгоор 500,000,000 (таван зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүнтэй нэг буюу хоорондоо холбоотой хэд хэдэн хэлцэл хийж, зарлага гаргахыг хориглоно.
- 11.2 Банкны ажилтнууд нь дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:
 - 11.2.1 Аливаа бусад байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх;
 - 11.2.2 Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж ажиллах ба банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, болон ажил төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст, тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдөд хууль бус давуу байдал олгохгүй байх;

Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан баримт бичиг, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд

зааснаас бусад тохиолдолд бусдад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ДААТГАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО

12.1 Даатгалтай холбоотойгоор Банк нь:

- 12.1.1 өөрийн бүхий л даатгуулж болох хөрөнгө, Банкны үйл ажиллагаа, хариуцлага мөн хуульд заавал даатгуулахаар заасан аливаа бусад эрсдэлийг салбартаа нэр хүндтэй даатгагчид хувьцаа эзэмшигч нарын хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр даатгуулах буюу өмнө байгуулсан гэрээний хугацааг сунгана. Даатгалын гэрээг англи хэл дээр байгуулна;
- 12.1.2 даатгалын гэрээ нэг бүрийг хүчин төгөлдөр хэвээр байлгах үүднээс шаардагдах бүх хураамж, төлбөрийг цаг хугацаанд нь зохих ёсоор төлнө;
- 12.1.3 тухайн үйл явдлаас хамаарч даатгалын тохиолдлын нөхөн төлбөр авах эрхэд халдаж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх, хийхийг завдахгүй, үйлдэх мөн эс үйлдэхийг бусдад зөвшөөрөхгүй;
- 12.1.4 даатгалын тохиолдлын нөхөн төлбөр авах тухай аливаа мэдэгдлийг холбогдох даатгагчид нэн даруй хүргүүлж, нөхөн төлбөрийг гаргуулах талаар бүхий л арга хэмжээг авч ажиллана;
- 12.1.5 Банкны гаргасан нийт хувьцааны 10 (арав) буюу түүнээс дээш хувийг эзэмшигчийн хүсэлтээр даатгалын хүчин төгөлдөр байдлыг нотлох баримт бичгийг гаргаж өгнө;

12.2. Байгаль орчин, нийгмийн бодлоготой холбоотойгоор ТУЗ нь:

- 12.2.1. Банкны бүх үйл ажиллагаанд даган мөрдвөл зохих Байгаль орчин, нийгмийн бодлогыг батална. Бодлого нь дараах үндсэн асуудлыг тусгасан байна:
 - (i) Байгаль орчин, нийгмийн бодлогын хүрээнд хөрөнгө оруулахыг хориглосон үйл ажиллагааны дэлгэрэнгүй жагсаалт;
 - (ii) Банкны зүгээс харилцагч болон түүний үйл ажиллагаанд тавих байгаль орчин, нийгмийн шаардлагууд (Байгаль орчин, нийгмийн шаардлага); болон
 - (iii) Байгаль орчин, нийгмийн шаардлагыг Банкны үйл ажиллагаанд ханган хэрэгжүүлэх үйл явц.
- 12.2.2. Байгаль орчин, нийгмийн бодлогын хэрэгжилтийг тайлагнах дотоод болон гадаад механизмыг батална; болон
- 12.2.3. Банкны хөрөнгө оруулалтын үр өгөөжийн үзүүлэлтэд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй Байгаль орчин, нийгмийн асуудлаар үүсэх магадлалтай болон тийнхүү үүссэн нөхцөлд үнэлгээ хийх, хяналт тавих журмыг баталж, дээр дурдсан асуудлаар Банкны удирдлага болон ТУЗ-д мэдээлнэ.
- 12.2.4. Байгаль орчин, нийгмийн бодлогын шинэчлэл, өөрчлөлт болон хэрэгжилтийн талаарх Байгаль орчин нийгмийн тайланг жил бүр бэлтгэн олон нийтэд нээлттэй байршуулна.

12.2.5. ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нь Байгаль орчин, нийгмийн бодлогыг таван жил тутамд хянаж, холбогдох хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. БУСАД

- 13.1. Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.
- 13.2. Банк нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС болон бусад дүрэм, журмын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлан гаргана.
- 13.3. Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа гишүүдийн Үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.
- 13.4. Энэхүү Дүрмээр тухайлан зохицуулаагүй асуудлыг тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй Холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна. Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг хянаж үзэн, тэдгээрт нийцүүлнэ.
- 13.5. Энэхүү Дүрэм буюу Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг Монгол Улсын хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.
- 13.6. Тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан энэхүү Дүрэм нь Банкийг татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хүчинтэй байна.
- 13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон Монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи хэл дээрх эхийг баримтална.
- 13.8. Энэхүү Дүрмийг Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар батлав.

ХасБанк ХК
Улаанбаатар хот

